



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.10.15, ДАВАА- №202 (1001)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Аль засаглал сайн бэ гэдэг маргааныг ард түмэн л тасална

Швейцар улс түүхэндээ 400 гаруй удаа ард нийтийн санал асуулга явуулсан байдаг. > 2

FT ШИЛДЭГ НИЙТЛЭЛҮҮД ТАНД ХҮРЧ БАЙНА > 9-10

FINANCIAL TIMES

Хүчирхийллээс сэргийлэх тогтолцоо хаанаа гажуудав?

Хүүхэд хамгаалах тогтолцоо бүрэн ажиллаж чадахгүй байна. > 5

ZGM DAILY FULL ENGLISH PAGE INSIDE > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Гадаад валютын зохицуулалтын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барив.
Вьетнам улстай ялтан шилжүүлэх гэрээ байгуулахыг ХЗБХ-ны гишүүд дэмжлээ.

ЭДИЙН ЗАСАГ
Дэлхийн ДНБ-ий өсөлтийн 60 хувийг Ази бүрдүүлж буйг ОУВС-гийн уулзалтаар онцлов.
СЗХ: III улиралд даатгалын 103 өргөдөл шийдвэрлэж, ₮576.6 саяыг нөхөн олгуулахаар шийдсэн.

НИЙГЭМ
БНСУ-д Монголын 44272 хүн оршин сууж байгаагийн 15478 нь хууль бусаар амьдардаг.

ДЭЛХИЙ
Криптовалют дэлхийн эдийн засагт аюул учруулж буйг ОУВС анхааруулав.
Дональд Трампын хүргэн хэдэн жил орлогын татвар төлөөгүйг New York Times илрүүлээ.

Төсөв дагасан татварын шинэчлэл ХҮЛЭЭЛТ ҮҮСГЭЛЭЭ



УИХ-н намрын чуулганаар татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, ААНОАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл багтсан. Эдгээр хуулийн төслүүд эдийн засаг, бизнесийн орчинд хүлээлт үүсгээд эхэлчихсэн байна. ►11

С.Батсайхан / ЗГМӨ

ТДВ
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Маамуу
ХҮҮХДИЙН ХАДГАЛАМЖ

ГАР ЗУРАГ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН

Би маамуутай хамт

5-7 нас
Гар зураг

Миний мөрөөдөл

8-10 нас
Бүтээл

Бүтээл ирүүлсэн хүүхэд бүр гарын бэлэгтэй

ШАГНАЛ:

Гар зураг болон бүтээлийн уралдаан тус бүрд

- I-р байр** - 500'000 төгрөгтэй
- II-р байр** - 300'000 төгрөгтэй
- III-р байр** - 200'000 төгрөгтэй
- IV-р байр** - 100'000 төгрөгтэй
- V-р байр** - 50'000 төгрөгтэй

Маамуу хүүхдийн хадгаламж

2018.10.26-ны өдрийг дуустал ХХБанкны төв байрны 1 давхарт бүтээлүүдийг хүлээн авна.

☎ 1900-1977

🌐 www.tdbm.mn

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1199 0.14%	6267 0.21%	94.670 0.04%	110.04 0.00%	97.870 0.00%	2,563.84	370.77	38.86

Улс төр

Үндсэн хууль

Аль засаглал сайн бэ гэдэг маргааныг ард түмэн л тасална

Швейцар улс түүхэндээ 400 гаруй удаа ард нийтийн санал асуулга хийсэн байдаг

Б.Энхжаргал
@enkhjirgZGM

Хүн төрөлхтөний мөнхийн сэдэв хайр гэдэг шиг Монголын парламентын ийм сэдэв нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай байдаг. Одоо ажиллаж буй парламентыг оролцуулаад тооцох юм бол сүүлийн дөрвөн ч удаагийн УИХ “эцэг” хуулийг өөрчлөх талаар ярьж, судалж, Ажлын хэсэг байгуулсаар иржээ. Ээлжит чуулган бүрийн хэлэлцэх асуудлын дараалалд багтдаг нь мөнхийн сэдэв болсны нотолгоо. Харин хамгийн сүүлийн буюу УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангийн ахалсан Ажлын хэсгийн боловсруулсан төсөл дээр үзэл бодлын олон талт мэтгэлцээн өрнөж байна.

Монгол Улс 26 жилийн турш мөрдөж буй шинэ Үндсэн хуульд 1999-2000 онд оруулсан өөрчлөлтийг “дордуулсан долоо” гэж нэрлэдэг. Харин тэр долоон дор заалтын дөрвийг нь энэ удаагийн өөрчлөлтөөр залруулна гэж Ажлын хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан хэлсэн.

1992 онд буюу нийгмийн шилжилтийн зааг дээр баталсан Үндсэн хууль өөрөө өнөөгийн нийгэмтэй нийцэж байна уу гэдэгт ард түмэн эргэлзэж байхад зөвхөн дордуулсан долоогийнхоо дөрвийг нь додомдуулснаар өдгөө Монгол Улсад бий болоод буй системийг, улс төрийн хямралыг арилгаж, шударга


төсөл Гадаад валютын зохицуулалтын тухай хуулийн төслийг өргөн барив

Ерөнхийлөгч Х.Баттулга Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулжээ. Уг төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд өргөн бариллаа.

Төгрөгийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын улсын нөөцийг эзэмшин удирдах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиг үүргийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглаж валютын орлого олдог хуулийн этгээдийн мөнгөн гүйлгээ, төлбөр тооцоог Монголбанк гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулсан байна.

Төсөлд Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигладаг, Монголбанкнаас тодорхойлсон хэмжээний экспортын гадаад валютын орлого олдог шаардлагыг хангасан хуулийн этгээдийн төлбөр тооцооны дансыг Монголбанк өөр дээрээ байршуулж болохоор тусгасан байна.

Хууль батлагдсан тохиолдолд Монголбанк өөр дээрээ байршуулсан, тодорхой шаардлага хангасан хуулийн этгээдийн дансаар дамжуулан гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, тэдгээрийн экспортын орлогыг Монгол Улсаар дамжуулах зэрэг үр нөлөөтэй гэж үзсэн байна. [ЗГМ]



С.Батсайхан / ЗГМ

ёс, хариуцлагатай байдлыг бий болгож чадах уу?

Эхлээд нэг статистик энд дурдъя. 1992 оны шинэ Үндсэн хуулийг батлахын тулд нийт 900 гаруй мянган иргэний саналыг авсан байдаг. Тухайн үед Монгол Улсын сонгуулийн насны иргэдийн тоо 1.1 сая байжээ.

Харин өдгөө нэмэлт, өөрчлөлт оруулахаар зэхэж буй төсөлд 330 орчим мянган иргэний саналыг авсан талаар Ажлын хэсэг тайлагнасан. Гэтэл Сонгуулийн насны хүн амын тоо 1.9 сая.

26 жилийн өмнө Монголын насанд хүрсэн нийт иргэний 81 хувийнх нь саналыг авч байж баталсан Үндсэн хуулийг өөрчлөхдөө сонгуулийн насны иргэдийн ердөө 17 хувийнх нь саналыг тусгах гэж байна гэсэн үг. Тэр “азтай” 17 хувь хэн байв? Мөн өөрийн биеэр буюу Төрийн ордонд болсон зөвлөлдөх санал асуулга гэх чамин нэртэй хэлэлцүүлэгт 785 иргэн оролцсон. Тэдний дунд намын гишүүд, төрийн байгууллагын ажилчид, УИХ-ын гишүүдийн туслах, зөвлөх, УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ-ын ажилтнууд гээд эрх

баригч хүчинтэй ойр хүмүүс багагүй жин дарсан нь үнэн. Тэд Үндсэн хуулийг өөрчлөх түүхэн үйл явдлын оролцогчийн нэгд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсоноо зарлаж, хувийн социал сүлжээндээ зураг, сэтгэгдлээ оруулж байсан нь саяхан. Монгол Улсад сонгуулийн насны 1.9 сая хүн байхад санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 785 дотор шүү. Бас л их хувьтай хүмүүс гэж харах уу, түүврийн арга нэртэй луйвар болчихлоо гэж хардах уу. Мөн зарим эх сурвалжийн хэлснээр томоохон компанийн ажилчдыг дайчлах байдлаар санал бичүүлж авсан тухай дурдсан. Энэ талаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн Ажлын хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан өөрөө ч үгүйсгээгүй юм.

Тэгэхээр ийм санал асуулгын үр дүн дээр суурильж, нэг нам үнэмлэхүй олонхыг бүрдүүлж буй УИХ-ын боловсруулсан төслийг баталснаар нэг л болж өгөхгүй байгаа Монгол Улсын засаглалын хямрал, хууль шүүхийн байгууллагад үл итгэх байдал, төрийн байгууллагын

гажуудлыг засаж чадахгүй нь мэдээж.

Үндсэн хуулийн өөрчлөлтөд сонгуулийн насны иргэдийн 17 хувийн саналыг тусгасан

1992 оны Үндсэн хуулиар Монгол Улсын засаглалын тогтолцоо нь олон улсын практикт түгээмэл бус улсад л байдаг холимог тогтолцоо гэж үздэг. Парламентын тогтолцоотой, бүх ард түмнээс сонгогдсон хүчтэй Ерөнхийлөгчтэй. Мөн дордуулсан долоогийн “ачаар” өнөөдөр л гэхэд үнэмлэхүй олонх парламентын бүлгийн гишүүдийн 20 гаруй хувь нь Засгийн газартаа давхар ажиллаж байна.

Парламент нь Засгийн газраа хянаж чадахаа байсан, гүйцэтгэх засаглал нь намын хараат болсон, Ерөнхийлөгч шүүх эрх мэдлээ

хэрэгжүүлэх Үндсэн хуулийн зарчим алдагдсан, төрийн алба чадавхгүй, хэврэг, ард түмний амьдрал баян ядуугийн туйлд хуваагдсан, орлогын эрс ялгарал бий болсон гээд тооцоод байвал түмэн “зовлон”-гийн суурийг Үндсэн хууль үүргээ гүйцэтгэж чадахгүй болсонтой холбон тайлбарладаг. Тиймээс дордуулсан гэх долоон заалтынхаа дөрвийг нь засах байдлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийснээр дээрх өвчин эдгэхгүй.

УИХ 2010 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баталсан. Ажлын хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан тус хуулийн хүрээнд буюу Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын хүрээнд өөрчлөлт оруулах хэмжээ, хязгаар тавьсан гэж хэлсэн.

Гэвч тус хуульд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах, бодитой ил тод байх зарчмыг баримтална гэж заасныг мартсан бололтой. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийг өөрчлөхдөө санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон гэх

мянга хүрэхгүй хүн Монголын гурван сая гаруй хүнийг төлөөлж чадахгүй. Тиймээс Үндсэн хуулийг хэрхэн өөрчлөх, засаглалын амар тогтолцоог дэмжих талаар нийт ард түмний санал асуулгыг зохион байгуулж, эргэлзээг тайлах нь шударга. Өөрөөр хэлбэл аль засаглал сайн бэ гэдэг сэдвээр улстөрчид, намууд хэрэлдэж суухаар ард түмнээсээ л асууя. Монгол Улсын гурван сая хүн хэрхэн, яаж амьдрах, хөгжих тухай гол баримт бичгийг боловруулахдаа бүх ард түмний саналыг тусгая л гэсэн үг.

Тухайлбал, Швейцар улс 400 удаа ард нийтийн санал асуулга явуулж, сонгууль маягаар зохион байгуулсан байдаг. Том гэлтгүй органик хуульд ч санал асуулга явуулдаг соёл тус улсад тогтчихсон байна. Ард түмнээсээ асуудаг дэлхий нийтийн соёлыг Монгол Улс бий болгож яагаад болохгүй гэж. Төрийг удирдахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж байгаа хамгийн том хэлбэр нь энэ шүү дээ. Яах вэ, том өөрчлөлтийг хийх, зөв замдаа ороход хэдэн төгрөг л зарлагдана биз. [ЗГМ]

ПАРЛАМЕНТ

Х.Баттулга: 2020 оны сонгуульд нөлөөлөх талаар илүүтэй бодсон төсөв байна

ЗГ-ын өргөн барьсан төсвийн төслийг энэ хэвээр нь баталбал Ерөнхийлөгч хориг тавина

Б.Сэлэнгэ
ЗГМ

Засгийн газраас өргөн барьсан 2019 оны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг УИХ өнгөрсөн баасан гарагт хийлээ.

Энэ өдөр чуулганы хуралдаанд Ерөнхийлөгч Х.Баттулга оролцсон бөгөөд тэрбээр төсвийн төслийг “хэт өөдрөг, айсуу хямралыг огт тооцоогүй, бодит амьдралаас тасарсан, 2020 оны сонгуульд нөлөөлөх талаар илүүтэй бодсон, ашиг сонирхлын зөрчлөөр дүүрэн болжээ” хэмээн дүгнэв.

Тэрбээр “Маш олон жил давтагдаж байгаа сонгуулийн өмнөх жил гишүүдийг аргадаж, тойрогт нь хийх хөрөнгө оруулалтыг өсгөх замаар “авлигддаг” зуршлаас Засгийн газар салаагүй байна. 2000-2004



онд Н.Энхбаяр Ерөнхий сайд байхдаа 72 гишүүнийхээ хэл амыг дарахын тулд нэг сая төгрөгөөр эхэлсэн “гишүүний мөнгө” гэгдэх тухайн тойрогт хийгдэх хөрөнгө оруулалт өнөөдөр таван тэрбум төгрөгт хүрч, 5000 дахин өсчээ. Үүнд УИХ-ын гишүүд өөрсдөө шүүмжлэлтэй хандаж байгаад

олзуурхаж байна. Улсын төсөв нэгэнт төлөвлөгдсөний дараа гишүүд сонгогдсон тойрогтоо зураг төсөв нь ч гараагүй барилга байгууламж нэмүүлж байна. УИХ-ын гишүүн Ч.Улааны хэлснээр шинээр эхлүүлэхээр төсөвлөсөн 570 барилгын 66 хувь нь буюу 375 барилга огт зураг, төсөвгүй байгаа

нь төсвийн тухай хуулийн 29.4-ийг зөрчиж байна. Хөдөө орон нутагт баригдах нэг объектын жишиг өртөг ойролцоогоор нэг тэрбум гэж багаар тооцоход дор хаяж 400 тэрбум төгрөг хэмнэж болохоор байна. Зураггүй, төсөвт өртөг нь тодорхойгүй барилга байгууламж олон жил дамнан, жил ирэх бүр өртөг нь нэмэгдэж төсөвт дарамт учруулдаг. Хууль зөрчсөн эдгээр объектуудыг ард түмэн “гишүүний мөнгө” гэж нэрлэж заншжээ. Эдгээр 375 барилгын төсвийн төсөөс хасах саналтай байна” хэмээв.

Ерөнхийлөгч Х.Баттулга “Хэрвээ эдийн засгийн үзүүлэлтүүдэ тогтож харвал сайжирсан зүйл огт байхгүй. Инфляц өссөн, төгрөгийн ханш эрс суларсан. Инфляц 2015 оны эцэст 1.9 хувьтай байсан бол өнөөдөр он дуусаагүй байхад 8.8 хувь болж өсчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 оны зургадугаар сард 1950 байсан бол өнөөдөр 2552 болж 602 төгрөгөөр суларсан байна. Энэ юуг хэлж байна вэ гэхээр Засгийн газар, Монголбанк инфляц, төгрөгийн ханш хоёрыг тогтвортой барих үүргээ биелүүлээгүйгээс өнөөдөр бараа үйлчилгээний үнэ өссөнөөс

монгол хүн бүрийн орлого алдагдаж, нийгмийн ачааг голлон нугалдаг дунд давхаргыг үгүй хийж байна. Бензин шатахууны үнэ 19-30 хувиар өсчихөөд байхад салбарын сайд, Засгийн газар хариу үйлдэл үзүүлэх чадваргүй суусаар байна” хэмээв.

Мөн тэрбээр Монгол Улсын өрийн хэмжээг онцлов. 2016 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын өр 16 их наяд 612 тэрбум төгрөг байсан бол одоо 21.1 их наяд төгрөгт хүрсэн. Өр нэмж тавихгүй, зээл авахгүй гэж байсан эрх баригчид “Мазаалай” бондоор 500 сая ам.доллар, “Хуралдай” бондоор 600 сая ам.доллар, “Гэрэгэ” бондоор 800 сая ам.доллар зээлчихээд байгааг хэллээ. Монгол Улс 2021 оноос бондуудын бүтэн төлбөрүүдийг хийж эхэлнэ. Энэ нь цаг хугацааны хувьд түүхтэй эдийн үнийн уналтын мөчлөгтэй давхцаж байгааг Ерөнхийлөгч Х.Баттулга санууллаа.

Мөн Засгийн газрын өргөн барьсан төсвийн төслийг энэ хэвээр нь баталбал Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хориг тавина гэдгээ төгсгөлд нь хэлсэн юм. [ЗГМ]

Нийтлэлчийн булан

Учир нь ТОСК иргэдийг дарамтлагч том байгууллага болжээ

Ш.Даваадорж
ЗГМ

Авлигатай тэмцэх газраас Төрийн орон сууцны корпорацид (ТОСК) ажил үйлчилгээ чинь буруу замаар яваад байна шүү, алдаагаа даруй засаж залруул гэсэн хатуу анхааруулга өгсөн байна. Эл анхааруулгыг ТОСК-ын Хэвлэлийн алба хөөрхөн өнгөлөн далдалж АТГ-аас манайд зөвлөмж ирүүлээ хэмээн нийтэд мэдээлжээ. Тэгвэл хэрхэн ажиллахаа мэдэхээ байгаад хөндлөнгийн нэгнээс зөвлөгөө авахдаа тултал энэ байгууллага доройтсон хэрэг гэж ойлгож болох нь тийм үү! Барилга, хот байгуулалтын яаманд иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн 80 гаруй хувь нь ТОСК-ын үйл ажиллагаатай холбоотой байсан учраас АТГ-аас ийн анхааруулга өгөхөд хүрч. Төрийн нэрийн өмнөөс ажилладаг энэ байгууллага яагаад иргэдийг ингэж гомдоогоод байдаг юм бол оо. Албан тушаалын дарангуйлал ноёрхож, иргэдийг дарамталсан, асар их өрийн сүлжээнд баглагдсан гэх эл байгууллага цаашид оршин тогтносон хэвээр байх уу?

Анх 2008 онд ТОСК байгуулагдсан юм. Тухайн үед орон сууцны үнэ гэнэт хөөсөрч, бэлэн мөнгө гаргаад орон сууц худалдаж авах бэлтэй хүн бараг байхгүй болсон хэцүү цаг үед Засгийн газраас авсан оновчтой арга хэмжээний нэг нь ТОСК-ыг байгуулсан явдал яах аргагүй мөн байлаа. Барилгын компаниуд орон сууцны нэг ам.метр талбайн үнийг 1.8 саяас таван сая хүртэл өсгөсөн. Сарын цалин нь хагас сая төгрөгт ч хүрдэггүй монголчуудаас ийм нөхцөлд удаан хугацаатай, хүү багатай зээлгүйгээр байртай болох ямар ч найдваргүй болсон. Тухайн үед арилжааны банкуудын гаргаж байсан 20 хувийн хүүтэй орон сууцны



С.Батсайхан / ЗГМ

Арилжааны аль ч банк ТОСК-тай тоож харилцахгүй байна. Төрийн байгууллага атлаа нэг ч банктай харилцаа холбоо алга.

дэлгүүр, үйлчилгээний ихэнх газар дээр дурдсан журмыг зөрчин байгуулагдаж, оршин суугчдыг амраахаа байсан бар, уушийн газруудын цаад эзэд нь үнэн хэрэг дээрээ ТОСК-ын удирдлагууд байдаг нь нууц биш. Тэд яагаад ийм давуу эрх эдлээд байна вэ? ТОСК-ын нэг ч ажилтан, албан хаагч иргэдээс давуу эрхтэйгээр хэрэгжүүлж байгаа төслийнхөө байранд орон сууц авах ёсгүй. Гэтэл ТОСК-ын олон албан хаагч дээрх хэрэгжсэн төслийн байранд орсон байдгийг юу гэж ойлговол зохилтой билээ. Албан тушаалаа хэтрүүлэн хэрэглэсэн хэрэг энэ мөн үү! Орон сууцны тухай хууль энд зөрчигдсөн эсэхийг шалгах л хэрэгтэй.

ТОСК нийгэмд маш нэр хүндтэй байгаа хэмээн залуухан дарга нь байгууллагынхаа сайтгад саяхан ярилцлага хийгээд тавьсан байна билээ. Өмнөх удирдлагаа баахан муучилсан хуншгүй яриа дүүрэн байсан. Тэгвэл үнэн байдал ямар байна вэ. ТОСК-ын байрныхаа урьдчилгаа мөнгөө бүр 50 хувь хүртэл төлсөн иргэд аль ч банкнаас ипотекийн зээл авч чадахгүй байна. Арилжааны аль ч банк ТОСК-тай тоож харилцахгүй байна. Төрийн байгууллага атлаа нэг ч банктай харилцаа холбоо алга.

Цөхөрсөн иргэд ТОСК-д тушаасан урьдчилгаа мөнгөө авах гэхээр өгдөггүй атлаа байрнаас нь хөөж туудаг үзэгдэл ердийн хэвшил боллоо. Бэлэн мөнгөтэй бэлтэй нэгэн ТОСК-д захиалга өгч, түүнийх нь дагуу ипотекийн зээлд орж чадаагүй байгаа иргэдийг байрнаас нь хүчээр гаргадаг үйл ажиллагааг ТОСК-ынхан эрхлэх болсны цаана авлига, хээл хахууль, албан тушаалын хэрэг цэцэглэж байж болзошгүй гэсэн иргэдийн хар үнэн байж мэдэх юм. Буянт-Ухаа хорооллуудын нэг давхрын байрууд бүгд үйлчилгээний газар болсон нь хачирхалтай биш гэж үү. Нэгэн цагт үүргээ гүйцэтгэсэн эл байгууллага эдүгээ төрийн нэр барьсан хамгийн үрэлгэн, хамгийн нэр хүнд муутай, хүнд сурталтай, иргэдийг өмнөө "сөхрүүлсэн" данхар бүтэц болжээ. Шуудхан хэлэхэд татвар төлөгчдийн мөнгөөр бизнес хийн амшиж байгаа энэ байгууллагыг татан буулгавал зохилтой биш үү! [ЗГМ]

ТОСК-ыг татан буулгая

зээлээр толгой хоргодох байртай болохоор зориглогдсон ихэнх нь өрөнд баригдаад дууссан юмдаг. Харин төрийн өмчит ТОСК байгуулагдсанаар иргэдэд найман хувийн хүүтэй орон сууцны зээл олгож эхэлсэн нь өнөөгийн ипотекийн зээлийн эхлэл байлаа. Анхны том төсөл болох төрийн албан хаагчдад зориулсан 40 мянган айлын орон сууц хөтөлбөр амжилттай хэрэгжсэн гэдгийг нь онцлох ёстой. Харин энэ бүхний дараагаас орлого багатай, зорилтот бүлгийн иргэдэд үйлчлэх үндсэн үүргээ ТОСК умартсан билээ. Төрийн өмчит улсын үйлдвэрүүдийн жишгээр төсвийн мөнгөөр, өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн мөнгөөр туйлдаг туйлын үрэлгэн байгууллага боллоо. Монгол Улсын эдийн засгийн судсанд шигдээд, цусыг нь сорогч хачиг, хувалз мэт бүтэц болж хувирсан гээд хэлчихэд лавтайяа хилс биш ээ. Шуудхан хэлэхэд ТОСК хэмээх нэртэй, төрийн нэрийг барьж татвар төлөгчдийн

мөнгөөр хувийн бизнес хийдэг байгууллага Монголд нэгээр нэмэгдчихлээ. 2013-2014 онд ТОСК ТӨҮГ-аас хэрэгжүүлсэн "Буянт-Ухаа 1", 2014-2015 онд хэрэгжүүлсэн "Буянт-Ухаа 2" төслүүд эл байгууллагын нүүр царай хэрхэн өөрчлөгдсөнийг гэрчилдэг.

Татвар төлөгчдийн мөнгөөр бизнес хийн амшиж байгаа энэ байгууллагыг татан буулгавал зохилтой биш үү

Төрийн мөнгөөр орон сууцны барилгыг хэрхэн чанаргүй барьж болдог вэ гэдгийг тэд "Буянт-Ухаа 1" төслөөрөө яруу

тод жишээлсэн буюу. ТОСК болохоор бороо, цас орохоор ус нэвт гоожсон, будаг, шохой нь хуурч, хана туурга нь хөгцөрсөн барилга барьснаа зөвтгөн харин ч нэг ам.метр талбайг нь нэг сая 250 мянган төгрөгөөр үнэлсэн хаа ч байхгүй хямд байранд "хуцалгүй" дуугүй орцгоо гэж иргэдэд хандсан юмдаг.

Тухайн үед хэвлэл мэдээллийн салбарынхан ТОСК-ын үнэн төрхийг баримтаар илчилж байж даварсан байгууллагын дэвэрсэн "ханд"-ыг нь дарсан түүх саяхных билээ. Эдүгээ бараг 100 шахам ажилтантай болж данхайсан үрэлгэн бүтэцтэй эл байгууллагыг татан буулгах талаар хөндөж, хууль тогтоох байгууллага дээр нэг биш удаа яригдсан нь бий. Учир нь ТОСК иргэдийг дарамтлагч маш том байгууллага болж. Үүнийг БХБЯ-ны нэр дээр ирүүлсэн иргэдийн олон зуун гомдол гэрчилнэ. Уг нь төрийн нэрийн өмнөөс иргэдийг орон сууцжуулах төсөлд нь зөвхөн менежмент хийх үүрэгтэй

байгууллага маань болохгүй, бүтэхгүй бүхний үүр уурхай болон хувирчээ. Орон сууц түүрээслэх өргөдлөө өгсөн олон хүнд хариу өгч, шийдвэр гаргалгүй удна. Тэгсэн атлаа аль хэдийн нөгөө орон сууцаа өөр нэгэнд борлуулчихсан байдаг нь хачирхалтай санагддаг.

Монгол Улсын хэмжээнд хамгийн хямд үнэтэй орон сууцны барилга бол яах аргагүй ТОСК-ын захиалж бариулсан барилга байдаг. Харамсалтай нь захирал, дарга нарынх нь сурталчлаад байдаг шиг тэдний мэргэн, түргэн ухааных биш билээ. Тэдний "мэргэн" ухаан хэрэгжүүлсэн төслийнхөө хүрээнд хэрхэн хөрөнгөжиж, хөлжих вэ гэдэг дээрээ жинхэнэ ургаж ундардаг болохыг "Буянт-Ухаа 1, 2" төслүүдээс харж болдог. Орон сууцны хороолол дунд бар, караоке байгуулахыг хориглосон журам бий. Харин энэ журмыг үл тоодог нөхдүүд бол ТОСК-ын удирдлагууд. Өнөөдөр "Буянт-Ухаа 1, 2" хороололд

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Нийгэм

Монгол улс анх удаа нийслэл, аймаг, сумын болон хадлан, бэлчээрийн газрыг үнэлжээ

П.Батбөх
ЗГМ

Засгийн газрын тогтоолоор анх удаа төрийн өмчийн газрыг үнэлсэн нь улс өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой шийдвэр хэмээн мэргэжилтнүүд дүгнэж байна. Одоогоор иргэд л өмчилсөн газраа банкинд барьцаалах хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулдаг. Харин төрийн өмчийн газрыг үнэлсэн дүн байдаггүй учраас ийм боломж байхгүй. Хэдий төр газраа өмчлөөгүй ч далд эдийн засагт хамгийн эрэлттэй арилжаа бол газрын наймаа болоод байгаа нь нууц



С.Батсайхан / ЗГМ©

Нийслэлийн нэгдүгээр бүсэд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай нэг га газрын үнэлгээг 1.2 тэрбум, бүх төрлийн үйлдвэрлэлийн газрыг 1.4 тэрбум төгрөгөөр тогтоожээ.

Худалдаа үйлчилгээний талбай, газрын үнэлгээ иргэд, бизнесийнхний анхаарлыг зүй ёсоор татна. Нийслэлийн нэгдүгээр бүсэд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай нэг га газрын үнэлгээг 1.2 тэрбум, бүх төрлийн үйлдвэрлэлийн газрыг 1.4 тэрбум төгрөгөөр тогтоосон байна. Харин 16-р бүсэд худалдааных 192 сая, үйлдвэрлэлийнх 72 сая төгрөг байх юм. Орон нутаг дахь худалдаа, үйлчилгээний төрлийн газрын хамгийн өндөр үнэлгээг мөн л Дархан-Уул аймгийн нэгдүгээр бүсэд нэг га газар 500 сая төгрөг, Завхан, Булган, Архангай аймгийн төвийнх 100 сая төгрөгийн үнэлгээтэй байна гэж тогтоожээ. Булган, Зуунмод хотод нэг га газрыг хамгийн хямд буюу 20 сая төгрөг байхаар тооцсон байна. Аймгийн төвүүдийн хамгийн үнэтэй, бүх төрлийн үйлдвэрлэлийн зориулалттай нэг га газар Орхон аймагт 400 сая төгрөг, Хамгийн бага нь Булганы төвд 15 сая төгрөг байна.

Нийслэлийн нэгдүгээр бүсэд өмчилсөн газрыг 57.2 сая төгрөгөөр үнэлжээ

биш. Хэрэв төр газрын үнэлгээг аль эрт хийсэн бол төрийн өмчийг хэн нэгний “зууш” болгохгүй, төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж дүүрэн байжээ. Гэхдээ хожимдсон ч гэлээ төрийн болон хувийн өмчийн газрын үнэлгээг тогтоож өгсөн нь эдийн засагт чухал нөлөө үзүүлнэ. Тус үнэлгээг төрийн санхүүгийн тайлагналд ашиглан гарган үнэ тогтоосноос хойш тухайн газрын үнэ төрийн тогтоосон ханшаар баталгаажих барьцаалбар болох учиртай.

ангилаар суурь үнэлгээ тогтоосон байна.

Дархан-Уул аймагт нэг га газар 500 сая төгрөгөөр үнэлэгдэв

Мөн нийслэл, аймаг, зарим сумын төвийн газрыг зориулалтаар нь ангилан үнэлжээ хийжээ. Тухайлбал, нийслэлийн төвийн таван дүүргийн газрыг зориулалтаар нь ангилан 16 бүсчлэлд хувааж нэг га /100х100 метр/ газрын үнэлгээг тогтоожээ. Түүгээр гэр бүлийн хэрэгцээний 0,07 га газар

Нийслэлийн дүүргүүдийн нэгдүгээр бүсийн нэг га газрын үнэлгээ (сая төгрөг)



нийслэлийн нэгдүгээр бүсэд 57.2 сая төгрөгөөр үнэлэгдэж байна. Мэдээж энэ ангилалд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн хотын төвд ойрхон гэр хорооллын өрхийн газар орно. Харин нийслэлийн төвийн таван дүүргийн хамгийн хол байршилд буй гэр бүлийн

хэрэгцээний газар 1.2 сая төгрөгөөр үнэлжээ. Эл үнэлгээг тогтоохдоо зах зээлийн зарчмаар төвөөс алслагдах тутам үнэ нь буурахаар тооцож хийсэн аж. Энэ мэтчилэн нийслэлийн алслагдсан дүүрэг болон 21 аймгийн төвийн газрыг ч мөн

бүсчлэлд хувааж, үнэлгээ тогтоогоод байгаа юм. Дархан-Уул аймгийн төвийн нэгдүгээр бүсийн өмчилсөн нэг га газрыг хамгийн өндөр буюу 240 сая төгрөгөөр тогтоосон бол Булган аймгийн төвийнх 40 сая төгрөг байна.

Үүнээс гадна хадлан, бэлчээр, тариалангийн зориулалттай газарт үнэлгээ тогтоогоод байгаа. Үндсэндээ энэхүү үнэлгээг хийснээр гаднын Элчин сайдын яамдад өгснөөс бусад бүх газар үнэлгээтэй болж байна гэсэн үг. Мөн хувийн өмчлөлийн газраас бусад үнэлгээ нь тогтоогдсон төрийн хөрөнгө болж тооцогдоно. Тэр хэрээр төрийн нийт хөрөнгийн хэмжээ өснө. Түүнийг дагаад Дэлхийн банк, АХБ, ОУВС зэрэг олон улсын санхүүгийн байгууллагаас авах зээлийн хэмжээ ч нэмэгдэх учиртай. НИТХ гэхэд л ирэх онд өмчөө барьцаалж Дэлхийн банкаас зээл авахаар хуульд өөрчлөлт орохыг хүлээж байна. Аймгуудад ч бас ийм боломж үүсэх ёстой. Мөн уул уурхайн нөхөн сэргээлтийн хохирлыг ч энд тооцсон үнэлгээгээр гаргуулдаг болж мэдэх юм. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРИОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лагажавын СУГАРМАА
Утас: 99903574

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энжжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903578
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР
zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

Millennium Challenge Account (MCA) – Mongolia

Closing Date: 17.00 ULAT, October 26, 2018

About MCA-Mongolia
The Government of Mongolia (“Government”) seeks qualified individuals to help organize, manage and lead a new special purpose entity to be known as the Millennium Challenge Account – Mongolia (“MCA-Mongolia”). The Government will shortly establish MCA-Mongolia in the form of a state-owned enterprise to oversee the implementation of the Mongolia Water Compact (the “Compact”), a major international development assistance program funded by the Millennium Challenge Corporation (“MCC”), a United States Government agency that provides grant assistance to help partner countries promote economic growth and reduce poverty.

The Compact aims to increase the long-term sustainable supply of water to Ulaanbaatar and stem the impact of an impending water crisis. The Compact will expand the supply of water to residential consumers and commercial and industrial users in Ulaanbaatar through:

- The construction of new groundwater wells downstream from Ulaanbaatar and introduction of a state-of-the-art water purification plant;
- The construction of a new freshwater recycling plant and pipelines to provide high-quality treated freshwater;
- Policy reforms, capacity building, and technical assistance to improve the long-term sustainability of Ulaanbaatar’s water supply.

MCA-Mongolia will oversee the implementation of these investments on behalf of the Government and in compliance with the guidelines and standards of MCC.

The Roles
DIRECTOR, LEGAL (GENERAL COUNSEL)
Main Tasks: The General Counsel serves as the principal legal officer for the management team and the Board of Directors of MCA-Mongolia. In this capacity, the General Counsel develops and provides policy advice and opinions on a wide range of legal matters. The General Counsel also serves as the corporate secretary to the Board of MCA-Mongolia. The General Counsel reports to the Chief Executive Officer (CEO) and manages one dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7696>

DIRECTOR, DOWNSTREAM WELLS
Main Tasks: The Director, Downstream Wells, manages the preparation and implementation of the Downstream Wells Activity, including the finalization, review, and approval of detailed designs; the development of work plans and risk mitigation strategies; the preparation of detailed procurement documents; and the implementation of complex construction works under tight budget and timeline constraints. The Director, Downstream Wells, also oversees portions of the Water Sector Sustainability Activity that involve small scale works in the ger areas of Ulaanbaatar. In the course of these responsibilities, the Director, Downstream Wells, works closely with design consultants, works contractors, a variety of implementing entities, and a program management consultant. The Director, Downstream Wells, reports to the Deputy Chief Executive Officer, Programs (the “Deputy CEO”), and manages three dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7699>

DIRECTOR, SUSTAINABILITY
Main Tasks: The Director, Sustainability, coordinates and manages support for policy, legal, regulatory and institutional changes that enhance the long-term sustainability of the water supply system in Ulaanbaatar, including the development and implementation of assessments, technical assistance and capacity building efforts in public entities at the local, municipal and national levels. The Director, Sustainability, establishes, communicates, and reinforces a common vision of change and coordinates the development of activity designs; the completion of bidding documents for all necessary procurements; the drafting of work plans and risk mitigation strategies; and the implementation of various activities. In the course of these responsibilities, the Director, Sustainability, works closely with the Director, Downstream Wells, to ensure the proper implementation of small-scale works in the ger areas of Ulaanbaatar and with other members of the Program Division staff. The Director, Sustainability, reports to the Deputy Chief Executive Officer, Programs (the “Deputy CEO”), and manages one dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7701>

DIRECTOR, COMMUNICATIONS
Main Tasks: The Director, Communications, leads and manages communications efforts related to the compact program, including media outreach, press placement and coverage, public information campaigns, and publicity events. In the course of these responsibilities, the Director, Communications, works closely with the Director, Environmental and Social Performance, to enhance stakeholder engagement activities and with the Director, Sustainability, to amplify public awareness and behavior change efforts related to public perceptions of water. The Director, Communications, builds strong relationships with the media, cultivates media opportunities for MCA-Mongolia officials, develops and implements a robust communications strategy, and serves as the official spokesperson for MCA-Mongolia. The Director, Communications, reports to the Chief Executive Officer (CEO) and manages two dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7706>

MANAGER, INFORMATION TECHNOLOGY
Main Tasks: The Manager, Information Technology, is responsible for the delivery and implementation of IT-related services to include network management and data infrastructure oversight, ensuring that services rendered support the work of the MCA. The Manager, Information Technology, reports to the Director, Administration, and supervises one dedicated staff member.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7709>

We are encouraging all interested parties to apply for the role. Selection process will be based on merit on the required experiences for all vacancies. Qualified applicants will receive consideration for employment without regard to race, ethnicity, religion, sex, national origin, or disability. No fees will be paid to MCA-Mongolia or any of its agents at any stage of the recruitment process (application, interview, processing, training fees or other).

SRI Executive (www.sri-executive.com) is assisting the Government of Mongolia in its search for exceptional candidates for MCA-Mongolia. SRI Executive operates under a contract provided by MCC. SRI Executive is supported by our local partner Specialized Career Consulting (SCC) in this recruitment initiative.

ЗГМ: Сурвалжилга



Асран хамгаалагчийн зөвшөөрөлтэй нийтлэв

Баянзүрх дүүрэгт гэр бүлийн орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, эрсдэлтэй нөхцөлд амьдарч буй хүүхдийн тоо нь бусад дүүргийнхээс олон байдаг.

С.Батсайхан / ЗГМ©

Хүчирхийллээс сэргийлэх тогтолцоо хаанаа гажуудав?

Хүүхэд хамгаалах тогтолцоо бүрэн ажиллаж чадахгүй байна

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Өнгөрсөн хоёр жилд гэр бүлийн орчин дахь хүчирхийллийг бууруулахад гарсан нэг дэвшил бол хороо, сум бүрт хамтарсан баг байгуулсан явдал. Сум, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, өрхийн эмнэлгийн нийгмийн ажилтан, цагдаа зэрэг 5-6 хүний бүрдэхүүнтэй хамтарсан баг хүчирхийлэлд өртөж байгаа иргэдэд тусалж, өртөх эрсдэлтэйг нь хяналт тавьж, урьдчилан сэргийлэх ёстой. Өнөөдрийн байдлаар манай улсад 609 хамтарсан баг ажиллаж байгаагаас 157 нь нийслэлд бий. Бид хамтарсан багуудын талаар сурвалжлагаар Баянзүрх дүүргийн 2 дугаар хороог зорилго. Учир нь Баянзүрх дүүрэгт гэр бүлийн орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, эрсдэлтэй нөхцөлд амьдарч буй хүүхдийн тоо нь бусад дүүргийнхээс олон байгаа юм.

ДАРГА НАРЫН САЙХАН ЯРИА ДООД ШАТАНДАА ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА

Дарь-Эхэд байрладаг тус хорооны байранд очиход нийгмийн ажилтан С.Дэлгэрсайхан 15 настай хүү нь долдугаар сараас хойш гэртээ ирээгүй эмэгтэйтэй уулзаж байлаа. РС тоглоомонд донтсон хүү нь үе үе ингэж сураггүй тэнэдэг ч энэ удаад арай л олон сараар алга болсонд ээж нь санаа зовнижээ. Тэрбээр нэгэн төрийн бус байгууллагад хандсан ч хүүхдийнх нь сураг гараагүй тул хорооны хамтарсан багийнханд мэдэгдэж буй нь энэ аж. Гэвч хүүгийнхээ араас санаа зовж буй ээжид туслах, эрсдэлд орсон байх магадлалтай хүүг олох ажлыг хамтарсан багийнхан шууд эхлэх боломжгүй аж.

Учир нь хүүг хайхад зарцуулах шатахуун, гар утасны зардал энэ багт байхгүй. Хорооны цагдаа шуурхай хурал, дуудлага гээд завгүй байдаг учраас ийм ажилд ихэнхдээ нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нар явдаг учраас эрсдэлтэй байдаг аж. Гэсэн ч ажил, төрлөө зохицуулаад, өөрсдөө шатахууны мөнгөө гаргаад хүүгийн эрэлд гарахаар төлөвлөж буйгаа нийгмийн ажилтан С.Дэлгэрсайхан хэллээ.

Уг нь Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас энэ онд хамтарсан багуудын зардлыг нэмсэн учраас мөнгөний бэрхшээлтэй болсон гэх мэдээллийг манай сонинд өгсөн.

● **Байгууллагуудын уялдаа холбоо сулаас найман сартай хоёр ихрийг үл хайхрах хүчирхийллээс ангижруулж чадсангүй.**

● **Цалин багатай учраас хамтарсан багийн гишүүд байнга солигддог.**

● **Өнөөдрийн байдлаар манай улсад 609 хамтарсан баг ажиллаж байгаагаас 157 нь нийслэлд бий.**

Гэвч бодит байдал дээр яг хүчирхийлэлд өртөж буй хохирогч, өртөх магадлалтай иргэдтэй ажилладаг хорооны ажилчдад энэ санхүүжилт очихгүй байгаа нь харамсалтай. Уг нь дүүргээс хамтарсан багуудад сард 150 мянган төгрөгийн зардал олгодог юм байна. Гэтэл Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны хамтарсан баг сургийг нь сонссоноос бус нэг ч удаа авч үзээгүй аж. Хорооны ажилчид цалин багатай учраас энэ мэт зардлыг байнга хувиасаа гаргахад хүндрэлтэй. Дээр нь ажлын ачаалал, цалингаас шалтгаалж хамтарсан багийн гишүүд байнга солигдож, төсөв, зардал гаргаж хийсэн сургалт нь үр дүнгүй болох нь олон байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хамгийн олон шийдэгдээгүй кэйстэй хороодын нэг нь Ганц худаг орчмыг хамардаг Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо. Гэвч нийгмийн ажилтан нь дөнгөж хоёр хоногийн өмнө ажлаа авсан тул бидэнд мэдээлэл өгч чадсангүй.

УЯЛДАА ХОЛБООГҮЙ БАЙДАЛ ХАМГИЙН ТОМ СААД БОЛЖЭЭ

Хэд хэдэн хорооны хамтарсан багийн ажилтантай уулзаж байгууллагуудын уялдаа холбоогүй байдлаас болж хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажил удааширсан нь анзаарагдаж байлаа. Тухайлбал, найман сартай хоёр ихрүүдийн аав нь байнга архи ууж, хэрүүл шуугиан үүсгэдэг учраас хөрш айлынх нь эмэгтэй 108-д дуудлага өгчээ. Аав нь согтуу ирэх тоолонд ихрүүд уйлах нь сонстдог учраас ийнхүү хүүхэд хамгаалах байгууллагад хандсан байна. Гэтэл энэ мэдээллийг тухайн хорооны хамтарсан багийн ажилтан долоон сарын дараа мэдсэн гэнэ. 108 төвийнхон уг мэдээллийг харьяаллынх нь дагуу дүүргийнх нь Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн төв рүү нь шилжүүлсэн аж. Харин тэндээс хорооны хамтарсан баг

руу ирэхдээ ийнхүү олон сар саатжээ. Хорооны нийгмийн ажилтан мэдээлэл өгсөн иргэнтэй эргэн холбогдоход “Хэзээний юм яриад байна вэ. Тэр айл нүүчихсэн. Хаашаа явсныг нь мэдэхгүй” гэснээр хоёр ихрийг эрсдэлээс хамгаалах ажил таг зогссон байна.

Архины хамааралтай эцэг, эхтэй хүүхдүүд ихэнхдээ үл хайхрах хүчирхийлэлд өртдөг. Цаашлаад юу эс болохыг хэн мэдэх билээ. Хэрэв эрсдэлтэй хүүхдүүдийн талаарх мэдээллийг шуурхай дамжуулсан бол ядаж хүүхдүүдийн овог, нэрийг мэдэх боломж байсан. Гэвч байгууллагуудын уялдаа холбоо сулаас ийнхүү хоёр ихрийг үл хайхрах хүчирхийллээс ангижруулж чадсангүй.

Уг нь хамтарсан багуудыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, түүний дэргэдэх Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл удирдлага, арга зүйгээр хангах үүрэгтэй байдаг. Гэвч яг бодит байдалд дээрх зөвлөлийн оролцоо анхан шатанд сул байгаа нь харагдлаа. Хороо бүрт Иргэдийн нийтийн хурлаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хангах үүрэгтэй байдаг. Гэвч тэдний үйл ажиллагаа нь ихэнх хороодыг камержуулах, иргэдийг архинаас гаргах сургалт, эмчилгээнд хамруулах зэргээр

хязгаарлагдаж байна. Тэгээд ч энэ ажлыг нөгөө л хамтарсан багийн гишүүд хийдэг юм байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс хамтарсан багуудыг хэрхэн дэмжиж буй талаар тодруулахад “Бид хамтарсан багуудыг хариуцдаггүй, мэдээлэл өгөх боломжгүй” гэсэн хачирхалтай хариулт өгсөн юм.

Зарим хамтарсан баг нэг ч удаа төсөв авч үзээгүй

Вендом ордны алтадсан салонд хэсэг хүүхэд алмаас шигтгээтэй титэмд нүд унаган зогсоно. Напелеоны анхны эхнэр Жозефиний 1811 онд хийлгэсэн энэ титэм Chaumet фирмийн эртний бүтээл. Энэ долоо хоногт дээд зэрэглэлийн гоёл урлагч тус компани олон нийтэд үүдээ нээв. Парисын ядуу хорооллын хүүхдүүдэд зориулсан уг арга хэмжээнд оролцсон Алфред Нобелийн лицейн сурагч 15 настай охин “Тайхалт гоёмсог. Би урьд нь ийм газар ирж үзээгүй” хэмээн сүүрс алдав.

Chaumet-ын төлөөлөгч урлангийн түүхийг танилцуулахдаа энэ салонд 1849 онд Польшийн хөгжмийн зохиолч Фредерик Шопен амьсгал хураасан гэхэд нэг сурагч “Энд үү?” хэмээн нүдээ том болголоо. Зэрэгцээ өрөөнд дуран авай дор алмаас байрлуулсан байх агаад таазан дахь дэлгэцэнд уг чулууг хэрхэн засаж янзалсаар 57 талтай сүйн бөгж болгосныг харуулсан дүрс билэг үзэгдэнэ. Виам гэдэг хүү “Чулууг яаж засагийг харах сайхан юм. Үнэхээр сэтгэл хөдлөлт” хэмээв.

LVMH-ын зөвлөлийн дарга



BVM©

Манай компани санхүүгийн үр дүнгээс өөр юу ч мэддэггүй гэсэн хэвшмэл үзлээс салах ёстой гэсэн бодол төрсөн.



Бернард Арногийн том хүү зохион байгуулсан нээлттэй Антаун Арногийн 2011 онд анх өдрүүд хэмээх гурав хоногийн

арга хэмжээний үеэр ордны 56 салоны зарим хэсгийг нийтэд үзүүлдэг. Кристиан Диорын 1940-өөд онд шинэ хараагаа тунхагласан Парис дахь ателье, Асниер дэх Луй Виттоны гэр бүлийн байшингаас гадна LVMH-ын олон улсын салбар Италийн Дахин сэргэлтийн үеийн Эмилио Пуччийн ордон, Аргентиньдарсны брэндүүдийг энэ үеэр сонирхох боломжтой. Эдний ажилтан болон урлаач 3000 хүн дэлхийн 13 улсад ажиллаж, брэндийг мэдэхгүй хүмүүст үзүүлэх буюу худалдан авах боломж олгож байна.

Ийм арга хэмжээ дөрөв дэх удаагаа зохиогдож байгаа нь энэ бөгөөд 2016 онд 150 мянган үзэгч ирж байв. LVMH-ын олон нийттэй харилцах болон имижийг хариуцдаг Антуан Арно “Санаа нь маш энгийн. Манай компани санхүүгийн үр дүнгээс өөр юу ч мэддэггүй гэсэн хэвшмэл үзлээс салах ёстой гэсэн бодол төрсөн. Манай групп хийсэн зүйлээрээ бахархдаг хэдэн мянган хүн ажилладаг бөгөөд зуу зуун жилийн уламжлалтай эртний бүтээл болох орд харшийг хадгалж үлдэх ёстой” хэмээн өгүүллээ.



► S&P 500 индекс \$1.7 их наядыг хийсгэлээ

Кэти Мартин

Өнгөрсөн долоо хоногт дэлхийн зах зээлүүд гүнэт доошилсон нь хөрөнгө оруулагчдын дунд хямралын дараах өсөлт дуусаа гэсэн айдас трөөүүлэв. Түүнчлэн АНУ-ын эдийн засгийн өсөлтийг дагаад Холбооны нөөц хүүгээ цаашид дээшлүүлэх төлөвтэй байгаа тул сар эхлэнгүүт Засгийн газрын бодныг зарах арилжаа идэвхжлээ. Арилжаа хуримтлагдсаар өнгөрсөн лхагва гарагт Тайванийн технологийн хувьцаа голлодог зах зээл доош унаж, цаашаа Европт халдварлаж, эргээд АНУ-д цохилт боллоо. Тухайлбал, пүрэв гарагийн орой S&P 500 индекс 1.7 их наяд ам.долларын үнэлгээгээ алдсан бол дэлхий даяар хувьцааны үнээс 2.7 их наяд алга болжээ.

► Tencent Music хувьцаа гаргахаа хойшлуулав

Луис Лукас

Долоо хоногийн хувьцааны зах зээлийн догилтын анхны хохирогч тодорч, Хятадын технологийн Tencent Music хувьцаагаа Нью-Йоркт гаргахаа хойшлуулснаа зарлав. Байдлыг мэдэх банкны ажилтан “Зах зээл ийм байгаа үед IPO хийх нь унаж байгаа хутгыг барьж авахтай адил. Зах зээлд баатарлаг явдал хэрэггүй” хэмээн ярилаа. Tencent Music энэ сарын 22-нд хувьцаагаа худалдахаар төлөвлөж байсан юм. Гэвч лхагва гарагийн догилт компанийг эргэлзээнд оруулж, энэ оны сүүл хүртэл хойшлуулахаар шийдвэрлэв. Энэ онд IPO хийсэн Хятадын компаниудаас ялгаатай нь Tencent Music оны эхний хагаст 291 сая ам.долларын ашигтай ажиллажээ.

► Facebook цахим халдлагад эмзэг мэдээллээ алджээ

Шэннон Бонд

Өнгөрсөн сард илэрсэн цахим халдлагын улмаас 14 сая хэрэглэгчийн хайлтын ба байрлалын түүх гэх мэт эмзэг мэдээлэл алдагдсаныг Facebook хүлээн зөвшөөрлөө. Тус компанийн бүтээгдэхүүний менежментийн дэд захирал Гай Роузен хэлэхдээ уг халдлага нийгмийн сүлжээний түүхэнд хамгийн ноцтойг онцлоод эхэндээ таамаглаж байсан шиг 50 сая зөв 30 сая хэрэглэгчийн өгөгдөлд хамаарахыг мэдээлэв. Зохицуулагчид болон хууль тогтоогчид нийгмийн сүлжээ хувийн нууцлал ба аюулгүй байдлыг хэрхэн хамгаалж байгаад нарийн шалгалт хийж буй үед ийм хэрэг ил боллоо.



Тарифаас шалтгаалсан их нүүдэл эрчимжлээ

Харриет Агню

Ерөнхийлөгч Дональд Трамп Хятадтай үгээр дайтаж байгаа нь худалдааны хэмжээнд нөлөөлж байна. Гэхдээ олон хүний бодсоноос өөр замаар байж магадгүй. Номхон далайг туулах контейнерийн тээвэр эрс нэмэгджээ. Тээврийн хөлөг онгоцууд дүүрэн ачаатай хөвж байна. Удаан үргэлжлэхгүй байж болзошгүй өмнөд Азийн экспорт өссөөр байгаа. Бээжин ноён Трампын дайралтыг тухай бүрт нь няцаасаар байна. Засгийн газруудын хоорондын үл ойлголцол АНУ руу экспорт хийдэг компаниудын ирээдүйг тодорхойгүй болгож буй нь мэдээж. Стандартын 40 тоннын контей-

Худалдааны энэхүү сөргөлдөөн түүнчлэн үйлдвэрлэлийг Зүүн өмнөд Азиас шилжүүлэхэд түлхэц өгнө.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Том Хэнкок

Хятадын Жэньжян хот дахь Ford-ын дилер үйлчлүүлэгчгүй шахам байна. “Хэдхэн жилийн өмнө хагас, бүтэн сайнаар 50, 60-аад үйлчлүүлэгчтэй байдаг байлаа. Одоо бол арав орчим” хэмээн борлуулалтын менежер Дай Пэн ярьж байна.

Хажууд нь орших Buick-ын салон бас ч гайгүй. “Сүүлийн хэдэн сард үйлчлүүлэгч цөөрчихлөө. Ингэж цөөрөхийг 2008 оноос хойш хараагүй юм байна” хэмээн борлуулагч нь тайлбарлав.

Дэлхийн автомашины хамгийн аварга, хамгийн орлоготой нь болох Хятадын зах зээл зогсонги байдалд ороод байна.

БНХАУ-ын автомашины зах зээл эдийн засгийн эрчимт өсөлттэй зэрэгцэн бараг гучин жил цэцэглэн хөгжсөн юм. Өнгөрсөн 2017 онд БНХАУ-д 29 сая ширхэг автомашин борлогдсон бол АНУ-д 17 сая зарагджээ.

Долоо, наймдугаар сарын борлуулалт жилийн өмнөх үеийн үзүүлэлтээс буурсан дүнтэй гарсан тул General Motors, Volkswagen компани есдүгээр сарын борлуулалт сул гарна хэмээн тооцоолсон юм. Дундад улсын автомашины борлуулалт 1990 оноос хойш энэ онд анх удаа буурна гэсэн тооцоог Nomura гаргаад байна.

Ашиг орлогод нь амин чухал үүрэг гүйцэтгэдэг учраас авто үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа нь үндсэндээ БНХАУ-д төвлөрдөг. Гэвч дэлхийн тэргүүлэх авто үйлдвэрлэгчдэд энэ нь түгшүүрийн харанга дэлдсэн хэрэг болов.

“Хятадын нөхцөл магадгүй өнөөгийн гол эрсдэл ч байж болзошгүй”-г Хонконг дахь Bernstein-ий шинжээч Робин Жу БНХАУ-д болсон Volkswagen-ы тусгай хуралдаан дээр анхааруулав. “Сүүлийн хэдэн сар, долоо хоногт автомашин үйлдвэрлэлийн салбарт бүтцийн болон мөчлөгийн шинжтэй хүндрэл, БНХАУ болон тарифтай холбоотой түгшүүр зэрэг олон дарамт туларлаа. Энэ олон дарамт

БНХАУ-д автомашины борлуулалт 1990 оноос хойш анх удаа буурлаа.




BBM©

хариулжээ. Энэ жил Хятадын жижиглэн худалдаа өчүүхэн буурсан. Гэхдээ том зардалд тооцогддог автомашинд уг бууралт хүнд туссаныг шинжээч нар анхааруулав.

Улсын дугаарыг сугалаагаар олгодог түвэгтэй тогтолцооноос шалтгаалан Хятадын том хотуудад автомашин хувьдаа эзэмших нь амаргүй даваа. “Үнэ өндөр, элэгдэл хоргодол их атлаа хэрэглээ багатай машин гээч эдийг худалдаж авах нь эдийн засгийн хувьд ашиггүй. Машин унаснаас метрогоор явсан нь хурдан” хэмээн Шэньжэний үл хөдлөх хөрөнгийн компанид ажилладаг 25 настай Грасиа Ма тайлбарлав.

Цэцэглэн хөгжиж буй хуучин машины худалдаа ч автомашин үйлдвэрлэлийн салбарт бүрхшээл учруулдаг. БНХАУ-д хуучин

Аварга зах зээл нь царцаж, авто үйлдвэрлэгчид түгшиж байна



устгах төлөв бага байна”.

Хятад дахь борлуулалт нь өнгөрсөн гурван сард 15 орчим хувиар буурсныг GM мэдэгдлээ. Есдүгээр сард Хятад дахь борлуулалт мөн 11 хувиар унасныг

Volkswagen энэ долоо хоногт тайлагнав. Тус хоёр компанийн хувьд БНХАУ хамгийн том зах зээл нь.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар гадаадын импортын

брэндүүд БНХАУ-ын зах зээлийн 62 хувийг бүрдүүлж байсныг McKinsey тооцоолжээ.

Volkswagen, GM, Nissan компани татвар төлөхөөс өмнөх нийт орлогынхоо 25 хувийг зөвхөн БНХАУ-аас олдог. Bernstein-ий тооцоогоор BMW, Mercedes-Benz компани 2017 онд нийт орлогынхоо 40-өөс илүү хувийг тус улсаас оруулсан байгаа.

Удаашралын нөлөө Хятадын цар хүрээндээ хальж эхэллээ. Их Британийн Jaguar Land Rover компани Мидлэнд дэх Солихал үйлдвэрээ энэ сард хоёр долоо хоног амраах гэж буйгаа даваа гарагт зарласан. Энэ нь Хятад дахь тус компанийн борлуулалт есдүгээр сард 46 хувиар буурснаас үндсэндээ шалтгаалжээ.

Автомашин үйлдвэрлэлийн

салбарын захирал, шинжээч, хэрэглэгч нар зах зээлийн бууралтыг хэд хэдэн шалтгаантай хэмээн үзэж байна.

Бээжин, Вашингтоны худалдааны дайн гүнзгийрсэн нь Хятадын эдийн засгийг удаашруулж, хэрэглэгчдийн итгэлийг сулруулсан нь нэг шалтгаан. Мөн хуучин машины зах зээл цэцэглэж, унаа захиалгын үйлчилгээ эрчимтэй нэвтрэн, шатахууны үнэ өссөн зэрэг зөвхөн тус салбарын онцлог шинжтэй хүчин зүйлийн нөлөө ч их байгаа юм.

Bernstein-ээс Хятадын 1500 хэрэглэгчийн дунд саяхан явуулсан судалгааг үзвэл, “нийтийг хамарсан болгоомж”-оос шалтгаалан судалгаанд хамрагдагсдын 12 хувиар хувь нь шинэ оноос өмнө машин худалдан авах сонирхолтой хэмээн

машин худалдаа арван жилийн өмнө 2.7 сая ширхэг байсан бол 2017 онд 12.4 сая болж өслөө. Дунджаар 4.6 жил хэрэглэсэн машин борлуулж байгаа Хятадын хуучин машины зах зээл цаашид цар хүрээгээ тэлэх хандлагатай байгаа юм.

Эрчимтэй өсөж буй унаа захиалах үйлчилгээ ч шинэ автомашины зах зээлд сөргөөр нөлөөлж байна. Уг зах зээлд ноёрхдог Didi Chuxing компанийн үйлчлүүлэгчдийн тоо 500 саягай давжээ. Үйлчлүүлэгч нар жилдээ 10 тэрбум удаа зорцдог гэсэн тооцоог тус компани гаргаад байна. “Хуваалцах эдийн засаг уламжлалт тогтолцоог бут цохиж буй хэрэг” хэмээн Шанхай дахь Automobility консалтинг компанийг үндэслэгч Билл Руссо тайлбарлав.



Жижиглэнгийн банкны ачаар JPMorgan Chase-ын орлого өслөө



Лаура Нуан

АНУ-д жижиглэнгийн банкууд сайн ажиллаж, чанаргүй зээл багассаны ачаар JPMorgan Chase-ийн ашиг шинжээчдийн урьдчилсан тооцоолсноос гурван улирал дараалж даваад байна.

Хөрөнгийн үнэлгээгээрээ АНУ-д тэргүүлдэг банкны цэвэр ашиг сүүлийн улиралд 8.4 тэрбум ам.доллар буюу жилийн өмнөх үеэс 24 хувиар өссөн дүнтэй гарлаа. Уг өсөлт Bloomberg-ийн санал асуулгад оролцсон шинжээчдийн таамгаас 7.7 тэрбум ам.доллараар их байгаа юм.

Гуравдугаар улирлын нийт орлого 27.8 тэрбум ам.доллар болсон нь жилийн өмнөх үеэс таван хувиар илүү буюу шинжээчдийн таамагласан 27.4 тэрбумаас их байна.

“JPMorgan Chase энэ улиралд манай бизнесийн салбар бүрт манлай үзүүлэлттэй ажиллалаа” хэмээн тус банкны гүйцэтгэх захирал Жэйми Даймон тайлбарлав. “Эдийн засаг, геополитикийн тодорхой бус нөхцөл ихэссээр

ирээдүйд сөрөг нөлөөлж болзошгүй болоод байгааг үл харгалзан АНУ, дэлхийн эдийн засаг хүч чадлаа бэхжүүлсээр”.

Ашиг орлогын өсөлтөд хэт анхаарахаас болгоомжлох нь зүйтэйг KBW-гийн шинжээч Брайан Клэйханци анхааруулж байна. АНУ-ын шилдэг зургаан банкны хувьцааны үнэ сүүлийн гурван сард дунджаар 6.2 хувь, S&P 500 индексе 2.5 хувиар уналаа. Хамгийн сайн үзүүлэлттэй яваа банкуудын нэг – JPMorgan-ых долдугаар сарын 13-наас хойш 2.2 хувиар суларчээ.

АНУ-д компанийн татвар багассаны ачаар JPMorgan-ы төлөх татвар жилийн өмнөхөөс 500 саяар, зээлийн зардал 600 саяар буурч, сүүлийн улирлын тайлан сайн үзүүлэлттэй гарсан юм.

Тус группийн жижиглэнгийн болон орон нутгийн банкны (community bank) ажиллагаа онцгой сайн байж орлого нь жилийн өмнөх үетэй харьцуулахад 10 хувиар өсөж, 13.3 тэрбум

ам.долларт хүрлээ. Цэвэр ашиг нь 60 хувиар ихсэж, 4.1 тэрбум ам.доллар болсон байна.

JPMorgan-ы хүүгийн цэвэр ашиг жилийн өмнөх үеэс бараг долоон хувь өсөж гуравдугаар улиралд 14.1 тэрбум ам.долларт хүрлээ. Сүүлийн хэдэн сард хүүгийн цэвэр ашиг буурах нь гэсэн айдсаас үүдэн тус банкны үнэт цаасыг зарж орхисон хөрөнгө оруулагчдад уг өсөлт сануулга болж байна. Чанаргүй зээлийн зардал жилийн өмнөх үеэс 300 сая ам.доллараар багасаж нэг тэрбум ам.доллар боллоо.

JPMorgan-ы компанийн болон хөрөнгө оруулалтын банкны салбарын орлого хоёр хувиар өсөж, 8.8 тэрбум ам.доллар боллоо. Жилийн өмнөх үетэй харьцуулахад хувьцааны зах зээлийн орлого хоёр хувиар, тогтмол орлогын зах зээлийн орлого 10 хувиар буурав. Гэхдээ мөн хугацаанд үнэт цаасны орлого 17 хувь өссөн нь дээрх бууралтыг нөхөж байгаа юм.



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СӨНИН

IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна



ОНЛАЙН ЗАХИАЛГА

Улиралд: 5000₮
(62 дугаар)
Хагас жилд: 10000₮
(124 дугаар)
Жилд: 15000₮
(248 дугаар)



ХЭВЛЭМЭЛ ЗАХИАЛГА

Улиралд: 30000₮
(62 дугаар)
Хагас жилд: 60000₮
(124 дугаар)
Жилд: 120000₮
(248 дугаар)



ХОСОЛМОЛ ЗАХИАЛГА

(Хэвлэмэл + Онлайн)
Улиралд: 32000₮
(62 дугаар)
Хагас жилд: 65000₮
(124 дугаар)
Жилд: 125000₮
(248 дугаар)



tdbpay

QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт и-мэйл хаяг, утасны дугаараа бүртгүүлэн захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:

УЛААНБААТАР ХОТЫН БАНК

2600092954

тоот дансанд мөнгөө тушаана уу.

Эдийн засаг

Төсөв дагасан татварын шинэчлэл хүлээлт үүсгэлээ

Татварын хуулийн шинэчлэл эдийн засаг, бизнесийн орчинд шинэ хүлээлт үүсгэлээ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

УИХ-ын чуулганаар ирэх оны төсөв, мөнгөний бодлогыг хэлэлцэж байгаа энэ үед эдийн засагчдын байр суурь, тэдний дуу хоолой хамгийн чухал байдаг. Нөгөө талаараа тэд хамгийн эрэлтэй болж эхэлдэг цаг өдийд тохиож байна.

Блумбергийн Эдийн засагчдын клубийн энэ оны гурав дахь хэлэлцүүлэг “Улсын төсөв-Татвар-Валют” сэдвийн хүрээнд болж, дээрх асуудлаар чөлөөт ярилцлага хийсэн юм. Улиралд нэг удаа уулздаг тус клубийн гишүүд 2019 оны төсөв, мөнгөний бодлогын төслийн хүрээнд өөрсдийн санал, бодлоо хуваалцсан юм. Энэ намрын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, ААНОАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл багтсан. Эдгээр хуулийн төслүүд эдийн засаг, бизнесийн орчинд хүлээлт үүсгээд эхэлчихсэн байна.

Эдийн засаг 2017 оныхоосоо дээрдсэн ч гадаад өрийн дарамт, төлбөрийн тэнцлийн алдагдал, валютын ханшийн эрсдэл, эрдэс түүхий эдийн үнийн тодорхой бус байдал ноёлсон хэвээр байна. Ийм ээдрээтэй үед ирэх оны төсөв, мөнгөний бодлогыг УИХ хэлэлцэж буй. Засгийн газрын өргөн мэдүүлсэн 2019 оны төсвийн төслийн талаар эдийн засагчид байр сууриа янз бүрээр илэрхийлж байна. Төсөвтэй танилцсан эдийн засагчдын зарим нь “Хөөсөрсөн төсөв”

хэмээн тодотгожээ. Орлогыг хэт өөдрөг тооцоолсон нь ирэх оны төсвийн эрсдэл гэдгийг мөн анхааруулав. Сонгуулийн өмнөх жилийн төсөв хэмээн цагаатгаж болох ч одоогийн боломжоосоо хэтэрхий давсан гэж зарим эдийн засагч хэлж байна.

Эдийн засагч С.Болд “Бидний дээрээс хоёр жилийн турш нар ээж байна. Гэхдээ хэзээ бороо орохыг таашгүй. Өнгөрсөн хугацаанд уул уурхайн өсөлтийг дагаад хэрэглээ өссөн. Энэ нь импортын өсөлтөөр илэрч байна. 2019 оны энэ задгай, том төсөв макро эдийн засгийн 2020, 2021 оны нэлээн том эрсдэлийн суурь шалтгаан болно” хэмээсэн юм. Түүнтэй ижил байр суурьтай эдийн засагч цөөнгүй байна. Төсвийн талаарх өөрсдийн дүгнэлтээ хэлсэн эдийн засагчдын яриан дотор хэт өөдрөг, хөөсөрсөн гэсэн үг хамгийн их давтагдах аж.

● **2019 оны энэ задгай, том төсөв макро эдийн засгийн 2020, 2021 оны нэлээн том эрсдэлийн суурь шалтгаан болно гэв.**

● **Аль ч улс эдийн засгийн өсөлтөө таамагладаг. Гэхдээ өсөлтийн хувийг УИХ баталдаггүй.**

● **Төгрөгийн ханш суларч байгаа энэ үед төв банк валютын нөөцөөсөө зарах бус зузаатгах хэрэгтэй.**



С.Батсайхан / ЗГМӨ

Монголбанк ирэх оны ДНБ-ий өсөлтийг зургаа орчим хувьтай байхаар таамагласан. Энэ нь Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк, ОУВС-гийн төсөөлөлтэй нийцэж буй. Харин Сангийн яам үүнээс хоёр хувиар илүү буюу найман хувиар эдийн засгийн өсөлтийг тооцоолж байна. Нүүрсний экспортоо 42 сая тонн гэж тооцсон нь мөн анхаарал татна. Засгийн газар энэ зорилтдоо хүрэхийн тулд багагүй ажил хийх шаардлагатайг эдийн засагчид онцлов.

Дэлхийн банкны эдийн засагч Б.Алтанцэцэг төсвийн орлогын тооцоолол хэтэрхий өөдрөг байгааг бас хэлэв.

Тэрбээр “Бид зөвхөн дотоодын нөөц боломжоо харахаас гадна гадаад орчны нөхцөл байдлаа нухацтай харах, тэндээс ирж болох эрсдэл, сөрөг үр дагавар болгоныг тооцож үзэх хэрэгтэй” гэж сануулсан юм.

Тухайлбал, АНУ, БНХАУ-ын хооронд өрнөж буй худалдааны сөргөлдөөн цаашид дэлхийн эдийн засагт, ялангуяа манай экспортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүнд хэрхэн нөлөөлж болохыг ч харгалзах хэрэгтэй гэв. Мөн төгрөгийн ханш суларч байгаа энэ үед төв банк валютын нөөцөөсөө зарах бус зузаатгах хэрэгтэйг Б.Алтанцэцэг цохон тэмдэглэв. Ам.долларын эсрэг хөгжиж буй орнуудын валютын

ханш суларч байгааг тэрбээр мөн дурдсан юм.

Эдийн засагч Н.Энхбаяр ирэх оны төсвийн орлогын тооцоолол өндөр гэдгийг ч бас үгүйсгэнгүй. 2008 оноос хойш манай улс уурхайгаас хамааралтай эдийн засагтай болсон. Энэ нь төсвийн орлогыг төлөвлөхөд улам амаргүй болгосон гэж Н.Энхбаяр эдийн засагч өгүүлсэн юм. “Аль ч улс эдийн засгийн өсөлтөө таамагладаг. Өсөлт янз бүр байж болно. Гэхдээ өсөлтийн тоог УИХ баталдаггүй. Харин төсвийн орлого, зарлагыг баталдаг. Эндээс л үр дагавар гардаг” гэж тэрбээр нэмж ярилаа. [ЗГМ]

УУЛ УУРХАЙ

“Баруун ноён уул” ордоос гурван сая тонн нүүрс олборлоно

Э.Эрдэнэтуяа
Шинжээч

“Баруун ноён уул” ордын нүүрсний олборлолтын төлөвийг Австралийн хөрөнгийн биржэд бүртгэлтэй Tetrasom компани жилийн гурван сая тонн гэж тогтоожээ. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн танилцуулсан төлөвлөгөөнд компани зардлаа бууруулах үүднээс хэд хэдэн цооног нэмж өрөмдөх аж. Мөн нүүрсний борлуулалтаа нэмэхийн тулд

Монгол дахь хэрэглэгчидтэйгээ яриа хэлэлцээр хийхийн зэрэгцээ нийлүүлэх нүүрснийхээ хэмжээг тохиролцожээ. Өнгөрсөн сард цаг агаарын нөхцөл таагүй байсан нь нүүрсний улирлын гарцад нөлөөлсөн гэдгийг онцолсон. Гэхдээ 2019 оны эхэнд гурван сая тонн нүүрс олборлох зорилтдоо хүрэхийн тулд ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх бодлого бариталж буй. Арилжааны сүүлийн үеийн мэдээгээр тус компанийн хувьцааны ханш 1.4 хувиар буурч, 0.7 австрали доллар болжээ.

ХУВЬЦААТ КОМПАНИ

120 орчим компанийн хувьцааны хөрвөх чадвар хангалтгүй байна

Б.Дөлгөөнзул
Шинжээч

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилготой ажлууд эхлээд буйг МХБ мэдээллээ. Одоогийн байдлаар Монголын хөрөнгийн биржэд 200 гаруй компани бүртгэлтэй байгаа бөгөөд үүний 60 орчим хувийнх нь хувьцааны хөрвөх чадвар хангалттай бус байна

гэж үзжээ. Энэ нь МХБ-ийн 120 орчим компанийн хувьцааны хөрвөх чадвар муу байна гэсэн үг юм. Харин 95 компанийн үүргийн хэрэгжилт дутуу бол 32 компанийн хувьцааны арилжаа зогсоод буй аж. Иймээс бүртгэлтэй байх хугацаандаа хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй болон жилийн үйлчилгээний хөлсөө хоёроос дээш жил төлөөгүй компаниудыг хөрөнгийн биржээс хасах хүртэл арга хэмжээ авахаар болсон байна.

АЙЛЧЛАЛ

Д.Сумъяабазар сайд Торонтод ажиллалаа

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазараар ахлуулсан төлөөлөгчид энэ сарын 9-10-нд Канадын Торонто хотод ажиллалаа. “Тавантолгой”-г эдийн засгийн эргэлтэд оруулах тухай УИХ-ын 76 дугаар тогтоолын

биелэлтийг хангах ажлын хүрээнд ийн Торонтог зорьсон юм. Мөн Монголын хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй “Эрдэнэс Тавантолгой” компани олон улсын хөрөнгийн биржэд нийт хувьцааныхаа 30 хувьд

ПРО хийж, хөрөнгө босгохоор төлөвлөөд буй. Иймд тус ажлын хэсэг Торонтогийн хөрөнгийн бирж болон Канадын экспортыг хөгжүүлэх сангийн удирдлагуудтай уулзалт хийсэн юм. [ВГМ]

ХӨРШ

БНХАУ-ын гадаад худалдааны тэнцэл 32 тэрбум ам.долларын ашигтай гарлаа



Н.Номин-Эрдэнэ
Шинжээч

АНУ-тай худалдааны маргаантай хэвээр буй БНХАУ-ын экспортын өсөлт эрчимжсээр байна. Тухайлбал, тус улсын ам.доллараар нэрлэгдсэн экспортын

хэмжээ жилийн дүнгээр 14.5 хувиар өссөнийг БНХАУ-ын гаалийн удирдах газар мэдээлэв. Энэ үзүүлэлт нь Bloomberg-ийн шинжээчдийн таамагас бараг хоёр дахин илүү дүн юм. Түүнчлэн импортын хэмжээ нь 14.3 хувиар ахиж, гадаад худалдааны тэнцэл нь 32 тэрбум

ам.долларын ашигтай гарчээ.

АНУ-ын тарифын шинэ бодлого хэрэгжихээс өрсөж БНХАУ-ын экспортлогчид үйл ажиллагаагаа эрчимжүүлсэн нь ийнхүү экспорт өсөхөд нөлөөлсөн байна. Үүний сацуу тус улсын АНУ-д хийсэн экспорт жилийн дүнгээр 12 хувиар нэмэгдэж, импорт нь хоёрдугаар сараас хойш анх удаа 1.2 хувиар буурсан.

Ингэснээр АНУ-тай хийсэн худалдааны ашиг нь 34 тэрбум ам.доллар болж, өмнө нь байгаагаүй дээд хэмжээнд хүрчээ. Гэвч хоёр улсын худалдааны маргаан даамжирсан хэвээр байвал БНХАУ-ын экспортын эрч саарах эрсдэлтэйг шинжээчид хэлж буй. Жишээлбэл, АНУ БНХАУ-ын 250 тэрбум ам.долларын импортод тариф ногдуулсны нөлөөгөөр тус улсын эдийн засгийн өсөлт 0.6 хувиар буурах магадлалтайг Standard Chartered тооцоолжээ.

ЗГМ ТОВЧХОН

» **АРИЛЖАА**

25

Компани. Монголын хөрөнгийн бирж баасан гарагт 25 компанийн 557,808 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 11 компанийн хувьцааны ханш өссөн бол 10 компанийнх буурч, дөрвөн компанийн ханш тогтвортой байлаа. Үүнээс “Э-Транс логистикс” болон “Багануур” компанийн хувьцааны ханш хамгийн өндөр өслөө.

» **АЛТ**

1.2

Мянган ам.доллар. Алтны спот ханш 0.58 хувиар буурч, 1.2 мянган ам.доллар болжээ.

» **ИНДЕКС**

2.4

Их наяд төгрөг. Топ 20 индекс 20,463.15 нэгж болж, 0.14 хувиар өслөө. Ингэснээр зах зээлийн үнэлгээ нь 2.4 их наяд төгрөгтэй тэнцэв.

» **ГАЗРЫН ТОС**

71.3

Ам.доллар. WPI төрлийн газрын тосны ханш 0.52 хувиар өсч, 71.3 ам.долларт хүрлээ.

» **УРГАЦ ХУРААЛТ**

88.1

Мянган тонн. Ургац хураалтын ажил 65.5 хувьтай байна. Тариаланчид 194.7 мянган га талбайгаас 266.3 мянган тонн үр тариа, 158.6 мянган тонн төмс, 88.1 мянган тонн хүнсний ногоо тус тус хураажээ.

» **ЗАХ ЗЭЭЛ**

31

Сая рупи. Lamborghini Энэтхэгийн зах зээлд авто машины нийлүүлэлтээ гурав дахин нэмэхээр зорьж буй. Мөн Urus загварын автомашинаа тус улсын чинээлэг иргэдэд зориулан нийлүүлэх бөгөөд уг автомашин 31 сая рупи буюу 200 мянган ам.долларын үнэтэй.

» **УУЛ УУРХАЙ**

Литийн эрэлт 2025 онд 2017 оныхоос тав дахин өсөх төлөвтэй байна. Уг эрэлтийг дагаад сүүлийн гурван жилд литийн үнэ гурав дахин өсжээ.

» **ТЭРБУМТАН**

54.5

Тэрбум ам.доллар. Дэлхийн тэрбумтнуудын хөрөнгө он гарснаас хойш анх удаагаа их хэмжээгээр буурлаа. Хойд Америкийн тэрбумтнуудын хөрөнгө хамгийн их хэмжээгээр буюу 54.5 тэрбум ам.доллараар буурсан байна.

» **ХОХИРОЛ**

Энэ оны эхний есөн сард 28.6 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд учирсан хохирол нь 131 тэрбум төгрөгтэй дүйж буй. Үүний 24 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,563.84
Евро	2,972.90
Японы иен	22.83
ОХУ-ын рубль	38.86
БНХАУ-ын юань	370.77
БНСУ-ын вон	2.26

Эдийн засаг

Д.Должинсүрэн: Ипотекийн санхүүжилтийг ₮500 тэрбум болгосон ч хөөсрөлт үүсэхгүй



Б.Хасуй / ЗГМ©

Гэр хорооллоос орон сууцанд орох иргэд бодит эрэлтийн 60-70 хувь байна

3.Цэлмэг
@tselmegZGM

Орон сууцны зах зээлийн дунд болон урт хугацааны төлөв, санхүүжилтийн эх үүсвэрийн хүрэлцээний талаар зах зээлийн судалгааны “Тэнхлэг зууч” ХХК-ийн захирал Д.Должинсүрэн тэй ярилцлаа. Тэрбээр худалдан авах чадвараар баталгаажсан орон сууцны эрэлт ипотекийн санхүүжилтгүйгээр хангагдахгүй гэдгийг онцолсон юм.

БХБЯ-ны захиалгаар орон сууцны зах зээлийн судалгаа хийсэн. Орон сууцны зах зээлийн төлөв ямар байна вэ?

Ирэх гурван жилд орон сууцны эрэлт, нийлүүлэлт өнгөрсөн жилүүдийнхээс огцом өсөх, буурах төлөв ажиглагдахгүй байна. 2020 он хүртэл худалдан авах чадвараар баталгаажсан 33 мянга гаруй орон сууцны эрэлт бий болно. Гэтэл нийлүүлэлт 38 орчим мянга байх төлөвтэй байгаа нь орон сууцны илүүдэл гурван жилийн дараа ч хэвээр байна гэсэн үг. Нөгөө талаар, зах зээлийн бодит эрэлтийг хангахын тулд ипотекийн зээл зайлшгүй шаардлагатай. Яагаад гэвэл эдгээр өрхийн 70-80 хувь нь ипотект хамрагдахаар урьдчилгаагаар бүрдүүлээд явж байна. Өөрөөр хэлбэл, ипотекийн санхүүжилтийг бууруулаад байвал энэ эрэлт дагаад буурна. Ингэснээр илүүдэл улам л өсөх дүр зураг харагдаж байна.

Түрээсийн орон сууцны хөтөлбөр мөн зонсонг байдал байна. Зах зээлийн хөдөлгөөн ямар байна вэ?

“Энэ төрлийн орон сууцны хэрэгцээ яалт ч үгүй маш өндөр байна гэдэг нь зах зээлийн судалгаанаас харагдаж байна. 44 мянган айлд түрээсийн орон сууцны хэрэгцээ бий. Ихэнх нь урт хугацаанд түрээслэнгээ худалдаж авах боломжийг хүсэж байгаа тул цаашид ипотекийн ийм холимог шийдэл хэрэгтэй байна. Мөн Засгийн газрын бодлого утааг бууруулах гэсэн нэг л шүхэр дор явж байна. Энэ хүрээнд гэр хорооллын иргэд газраа эргэлтэд оруулах сонирхол маш өндөр байгаа юм. Эдгээр өрх урьдчилгаа төлбөргүй, тогтмол орлогогүй гэх мэт олон бэрхшээлтэй байдаг учраас орон сууц худалдан авах боломжгүй, цорын ганц найдвар нь газар болоод байгаа юм. Тиймээс өөр төсөл хөтөлбөрөөр дамжуулж иргэдэд газраа эргэлтэд оруулах боломж нээж өгөхгүй бол ипотекийн зээлийн нөхцөлөөс шалтгаалж орон сууцны бодлогыг тэлэх боломж хумигдаад байгаа юм.”

Зах зээлийн судалгааны дүнд үндэслэн ипотекийн зээлийн журамд ямар зохицуулалт тусгах шаардлагатай вэ?

Судалгааны үр дүнд тулгуурлаад ипотекийн журамд өөрчлөлт оруулах саналыг БХБЯ-наас тавьсан. Үүнд, зээлийн хүүг долоон хувь болгож бууруулах, урьдчилгаа төлбөрийг 30 хувиас багасгах, амины орон сууцны урт хугацааны санхүүжилт олгох гэсэн санал багтсан. Гэхдээ дийлэнх иргэд зээлийн хүүг бус урьдчилгаа төлбөрийг бууруулахыг л хүсэж байна. Өөрөөр хэлбэл, тэд хуримтлал үүсгэж амлаагүй. Түүнээс биш урьдчилгаа төлбөрийг 20-25 хувь болгочихвол цаашдаа зээлээ төлөөд явах чадвартай гэж хэлж байна.

Энэ онд ипотекийн санхүүжилтэд Засгийн газар, Монголбанк нийлээд 320 тэрбум төгрөг төсөвлөсөн. Гэтэл ирэх онд үүнийг 115 тэрбум төгрөг болгож бууруулах санал төсвийн

төсөлд тусгасан байна. Эх үүсвэр ингэж буурсан нь зах зээлд хэрхэн нөлөөлөх бол?

“Эрэлтийг маш их хэмжээгээр багасгана. Энэ онд л гэхэд одоогоор ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо хоёр мянга дөнгөж даваад байна. Үүнийг ипотекийн зээл эрчимтэй олгож байсан 2014, 2015 онтой харьцуулахад санхүүжилтийн эх үүсвэр нь бараг тав дахин буурсан гэсэн үг. Цаашид энэ чигээрээ үргэлжилбэл 33 гаруй мянган эрэлт хангагдахгүй, тэр хэрээр нийлүүлэлтийн илүүдэл зах зээлд үүснэ.”

Санхүүжилтийг нь бага тавьсан үзэл шалтгааныг үл хөдлөх хөрөнгийн үнэ өсөхөөс сэргийлсэн гэдэг тайлбар төсвийн төсөлд бий. Харин ийм үндэслэл зах зээлд бий юу?

“Их наяд ба 200 тэрбум төгрөгийн хооронд ялгаа мэдээж гарна л даа. Харин 100-200 тэрбум төгрөгийн зөрүүд бол зах зээлд дээр үнийн хөөсрөлт үүснэ гэж би хувьдаа харахгүй байна. Ер нь санхүүжилт 500 тэрбум төгрөг болж нэмэгдсэн ч үнийн хөөсрөл үүсэхгүй. Үүнээс хэтэрвэл харин магадгүй юм. Өнөөгийн нөхцөл байдлыг хар л даа. Банкуудад ипотекийн зээл олгох шийдвэр нь гарсан атлаа санхүүжилтээ авч чадаагүй маш урт дараалал байна. Үүнийг одоогийн эх үүсвэрээр арай гэж л залгуулж байна. Зах зээлийн бодит эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангахын тулд санхүүжилтийг хэвийн залгуулах хэрэгтэй. Түүнээс биш одоо хөөсрөлт үүсгэх тухай ярих болоогүй.”

Барилгын компаниудын хувьд түгжигдчихээд байгаа хөрөнгөө эргэлтэд оруулах, орон сууцаа борлуулах ямар арга зам эрэлхийлж байна вэ?

“Бүх л аргаа хэрэглэж байх шиг байна. Өөрсдөө бие даан хэрэглэж байгаа арга бол хашаа байшин, машин, өөр орон сууцныг нь урьдчилгаанд авах гэх мэт бартерийн системд шилжсэн. Цөөн хэдэн чадалтай компани өөрсдөөсөө шууд болон барил-


гын борлуулалтад зориулсан бага хэмжээний ББСБ байгуулаад зээл олгож байна. Харин массаар шийдэж буй нэг хувилбар бол барилгын компаниуд банк, санхүүгийн байгууллагатай хамтарч урт хугацааны, хүү багатай өөр эх үүсвэр эрэлхийлж эхэлсэн. Мөн МИК гаднаас эх үүсвэр татаж чадвал их том найдвар болно. Ер нь барилгын компани өөрөө бартерийн системээр явах нь маш хэцүү.”

Бодит худалдан авагчдын 70-80 хувь нь ипотект хамрагдахаар төлөвлөж байна

“Албан ёсны статистикаас харахад сүүлийн 1-2 жилд автомашины импорт огцом нэмэгдсэн. Ипотек саарснаар хүмүүс хадгалж, хуримтлуулж байсан мөнгөөрөө эргээд автомашины зэрэг импорт дэмжсэн худалдан авалт хийгээд байна уу гэж харахаар байна. Зах зээлд байгаа бодит эрэлтийн цаана хэдий хэмжээний бэлэн мөнгө яригдаж байна вэ?”

“Мэдээж орон сууцны урьдчилгаа төлбөрийн зарцуулалт автомашины худалдан авалт руу шилжих магадлал хамгийн өндөр. Иргэдийн дийлэнх нь дунджаар нэг ам метр нь 1.5 сая төгрөгийн үнэтэй, нийт 60 ам метр талбай бүхий орон сууцанд орох хүсэлтэй нь судалгаанаас харагдсан. Үүнийг ирэх гурван жилд худалдан авах чадвараар баталгаажсан 33 мянга гаруй өрхөд үндэслэн, урьдчилгаа 30 хувиа цуглуулсан гэж үзвэл зах зээлд бараг нэг их наяд орчим төгрөг байна гэсэн үг.”

Орон сууц нийслэлээс гадна орон нутагт хаана хамгийн өндөр эрэлттэй байна вэ?



“Дархан, Эрдэнэтэд орон сууцны нийлүүлэлт өндөр байгаа бол Хөвсгөл, Дорнод, Дорноговь, Орхон аймагт орон сууцны эрэлт өндөр байна.”

Судалгааг нэгтгээд харвал яг гэр хорооллоос орон сууцанд орох өрх хэр олон байна вэ?

“Орон сууцанд мөнгөө төлөөд, зээлдээ хамрагдаад ороход бэлэн байгаа 33 мянга гаруй өрхийн 60-70 хувь нь гэр хорооллоос орон сууцанд орохоор, үлдсэн нь орон сууцаа сайжруулах зорилгоор ирэх жилүүдэд орон сууц худалдан авна гэдэг дүн гарсан.”

Санхүүжилт саарангуут бэлэн мөнгөөр шууд худалдан авах орон сууцны үнэ маш их хямдарч байгааг иргэд хэлж байна. Зах зээлд ийм үзэгдэл хэр түгээмэл байна вэ?

“Ер нь байгаа. Худалдан авах чадвараар баталгаажсан 33 мянга гаруй өрхийн 5000 орчим нь бэлэн мөнгөөр худалдаж авна гэдгээ илэрхийлсэн. Өмнө хэлсэнчлэн барилгын компаниуд борлуулалтаа дэмжихийн тулд бараа солилцооны системд орсон байгаа. Гэхдээ эд бараагаар цалин тавих, бараа материал худалдан авах боломжгүй тул бэлэн мөнгө бириад ирсэн худалдан авагчид бол орон сууцныг нэлээд хямдруулж өгч байгаа жишээ элбэг байна.”

Санхүүжилт цаашид энэ чигээрээ хүртээмж муутай байвал орон сууцны үнэд ямар нөлөө үзүүлэх вэ?

“Үнэ бол буурахгүй байх. Хямд үнэтэй орон сууцнууд нэлээд бий. Гэхдээ 3-4 жилийн өмнөхтэй харьцуулахад зах зээл дээр үнэтэй орон сууцны нийлүүлэлт маш их болсон. Хямд орон сууцнаас үнэтэй рүү нь шилжих шилжилт байгаа учраас дундаж үнэ сүүлийн нэг жилд тогтвортой байгаа. Хүмүүс 30 гаруй мянган орон сууцны илүүдэлтэй гэж буруу ойлгоод байна.”

Үүний зарим нь 2020 онд ашиглалтад орно шүү дээ. Одоогоор жилд 5000 орчим л орон

сууцны илүүдэл байна. Гэтэл хүмүүс илүүдэл ийм их байхад одоо үнэ буурахаас гарцаагүй гэж тооцож байвал бодит байдал өөр гэдгийг анхааруулж хэлмээр байна. Нийт 260-270 мянган айлын орон сууц, 380 мянган өрхийн тухай ярьж байна. Энэ дунд 5000 орчим орон сууцны илүүдэлтэй байх нь үнэд төдий л их нөлөөлөхгүй.

Өнгөрсөн дөрвөн жилд ипотекийн санхүүжилт дөрөв дахин буурсан. Харин энэ хугацаанд орон сууцны үнэ хэрхэн өөрчлөгдсөн бэ?

“Дундаж үнэ бол өсөж байгаа. Эх үүсвэр хангалттай байх үед орон сууцны үнэ маш их өсөж, 25 хувь хүртэл хөөсөрч байна гэж ярьж байсан. Харин сүүлийн хоёр жилд огт хөөсгүй байна гэж харж байгаа. Гэхдээ ипотекийн санхүүжилт 4-5 дахин буурснаар орон сууцны үнэ буурсан гэж үзэх нь бас өрөөсгөл. Өөрөөр хэлбэл, одоо орон сууцны үнэ хамгийн бодитой байгаа гэж хэлнэ.”

Ипотекийн санхүүжилт саарахад барилгын компаниуд үнэхээр хүнд болсон. Одоо харин эдийн засаг тэлж байгаа нь барилгын салбарт хэрхэн нөлөөлж байна вэ?

“Нэг компани л барьж байсан барилгаа зогсооход цаана нь 40-50 ажлын байр үгүй болж, төдий тооны хүн хугацаагүй амралт авч, мөн төчнөөн гэр бүлийн орлого багасдаг. Ингэснээр зах зээлд эргэлдэж байгаа бэлэн мөнгө, өрхийн амьжиргаа гээд олон зүйлд сөргөөр нөлөөлсөн. Манай компани зах зээлийн судалгаагаа улирал болгон шинэчилдэг. Сүүлийн хоёр жилд үнэхээр барилгын салбар зогсонги байдалд ороод байсан. Харин энэ хавраас хөдөлгөөнд орж эхэлж байна. Макро дүр зургаар нь харвал, эдийн засгийн болон улирлын чанартай өсөлт. Түүнээс биш ипотект шиг барилгын салбарт эергээр нөлөөлөхөор ямар ч төсөл хөтөлбөр, бодлого өнгөрсөн хугацаанд байсангүй. [ЗГМ]”

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

